Ийм дайны үед хоёр талын тэмцэл явагдах ёстой талуудын зах нийлсэн зааг буюу фронтын шугам үүсэхгүй байлдааны ажиллагаа зэвсэгт мөргөлдөөн явагдаж байгаа нийт нутаг дэвсгэрийн хүрээнд хаана ч явагдаж болох бөгөөд байлдаан нь тодорхой нэг хэсэг газарт богино хугацаанд үргэлжлээд дуусчихдаг ба жижиг байлдаанууд өөр өөр газарт давталттай үргэлжилдэг онцлогтой байсан. Энэ ажиллагаанд дайсны санаачилгыг булаан авах үндсэн арга нь дайралт байсан. Дайралт хийсний дараа түргэн хугацаанд байрлалаа сольдог учраас эсрэг талаас устгах боломж олгодоггүй.

Орчин үеийн байлдаанд дайралтын олон төрлийн аргуудыг хэрэглэж байна. Жишээлбэл: галын дайралт; техникийн дайралт; минийн дайралт; гэнэтийн дайралт; тусгай дайралт; агаарын хөдөлгөөнт дайралт гэх мэт.

Тусгай томилолтын батальонуудыг хэрэглэсэн онцлог Афганистаны нутаг дэвсгэрт мотобуудлагын тусгай батальон нь тагнуулын ба тусгай олон төрлийн үүрэг гүйцэтгэж байсан. Тусгай томилолтын тагнуул нь бусад төрлийн тагнуул (агентурын, агаарын, химийн ба улсыг аюулаас хамгаалах байгууллагын тагнуул)-тай нягт харилцан ажиллагаатайгаар тагнуулын бүлэг, отрядын идэвхтэй ажиллагаатай хослуулсан аргаар зохион байгуулан явуулж байв. Тусгай томилолтын тагнуул нь самуун дэгдээгчдийн цувааг илрүүлж устгах, Исламын хороод, дээрэмчдийн бүлгүүд, зэвсэг галт хэрэгслийн агуулах, баазуудыг устгах

<sup>1</sup> Паламдорж, Ш., & Дашзэвэг, Ц. (2020). Цэргийн ерөнхий тактик

(бут цохих) тусгай арга хэмжээ явуулах үндсэн зорилготой байсан. Эдгээр үүргүүдийн багтаамж, агуулга нь цагийн байдлын нөхцөл, юуны урьд бүлэг, отрядын ажиллагаа явуулах арга (дайралт ба отолт), тагнан эрж илрүүлэх районоос хамаарч байсан болно. Дээрх үүргүүдийг биелүүлэхийн тулд батальон нь тагнуулын бүлэг, отрядад хуваагдана.

Агаарын тагнуулаар илрүүлсэн цувааг нарийвчлан тагнахын тулд шалган тогтоох бүлэг томилон ажиллуулна. Бүлэг, отрядын байлдааны ажиллагааг батальоноос томилсон хуягт бүлэг, тэрчлэн нисэх онгоц, нисдэг тэрэг, их бугаар дэмжиж байсан.

Зарим онцгой тохиолдолд тагнуулын бүлэг, отряд нь ерөнхий цэргийн анги, салбаруудтай харилцан ажиллагаатайгаар үүргээ биелүүлнэ. Бүлэг, отрядыг тагнан эрэх болон отолт зохион байгуулах районд явганаар, орон тооны техникээр болон агаараар тээвэрлэн гаргана.

Афганистан дахь байлдааны туршлагаас үзэхэд тухайн нөхцөлд агаараар тээвэрлэх нь илүү үр дүнтэй байсан болно. Орон тооны техник хэрэгслэлээр байлдааны ажиллагааны районд гаргасан бүх тохиолдлын 12% нь амжилтанд хүрч байсан бол агаарын тээврээр байлдааны ажиллагааны районд гаргасан бүх тохиолдлын 60% нь үр дүнтэй болсон байна. Үүнээс гадна цаг хугацаа, бие бүрэлдэхүүний хүч тамирыг ихээхэн хэмнэх ашигтай байсан.

Афганистаны нутаг дэвсгэрт тагнуулын бүлгийг байлдааны ажиллагааны районд агаараар буулгахад гарч байсан дутагдал нь нисдэг тэргээр буухын өмнө маневр, хуурамч суулт (агаарт зогсолт) хийхгүй байх болон зөвхөн өдөр гэрэлтэй үед гүйцэтгэж байсанд оршино. Үүнээс болж хүнд хохирол амсах тохиолдол гарч байжээ. Тухайлбал, ахлах дэслэгч Марьяков С.В.-ийн удирдсан 19 хүнтэй тагнуулын бүлэг нэгэн суурин газрын ойролцоо десантаар буужээ. Нисдэг тэрэг ямар нэгэн маневр, хуурамчаар агаарт зогсолт хийлгүй, шууд десант буулгах районд гарч суулт хийсэн байна. Нисдэг тэрэгний баг болон бүлгийн даргын энэхүү буруу ажиллагаанаас болж уг бүлгийг дайсан илрүүлсэн байна. Бүлэг тавигдсан үүргийг биелүүлж чадаагүйгээр үл барам, хүнээ алуулж хохирол амсчээ.

Энэ сургамжаас урган тагнуулын бүлэг, отрядыг агаараар тээвэрлэн үүрэг гүйцэтгэх районд гаргах ажиллагааг шөнийн цаг өргөнөөр гүйцэтгэх болсон болно. Шалган тогтоох бүлгийн ажиллагаанд задлан шинжилгээ хийж үзэхэд батальоны бие бүрэлдэхүүн энэ ажиллагаанд сайтар сургагдсан нь харагдсан юм. Шалган тогтоох бүлгийн нислэгийн төлөвлөлтийг бригад батальонд сараар хийж байсан юм. Батальоны байлдааны ажиллагааны үндсэн арга нь отолт байсан. Мотобуудлагын тусгай батальоны байлдааны ажиллагааны туршлагаас үзэхэд отолт нь ажиллагааны бусад аргуудаас нэлээд давуу талтай байсан.

Тухайлбал, дайсныг тэдний хувьд санаанд ороогүй, эвтэйхэн газарт нуугдан хүлээж, ойрын зайнаас гэнэтийн хүчтэй галаар сандралд оруулан, зохион байгуулалттай эсэргүүцэл үзүүлэх боломж олголгүйгээр устгах боломжтой юм.

Туршлагаас үзэхэд тагнан илрүүлэх районд бүлгийг 2-3 хоногийн хугацаагаар гаргаж, отолт зохион байгуулах нь үр дүнтэй байсан. Тэр тусмаа шөнийн цагт дайсныг отолтонд оруулж байлдах нь хамгийн үр дүнтэй юм. Энэ үед дайсан сандрал, эмх замбараагүй байдалд амархан орохоос гадна тагнуулчид хохиролгүй үүргээ гүйцэтгэх магадлал дээшилнэ. Гэвч энэ тохиолдолд отолтын дэд бүлгийн хоорондын харилцан ажиллагаа, удирдлагыг зохион байгуулахад бэрхшээл учирна. Уулархаг газар оронд отолтыг нарийн хавцлаар өнгөрч байгаа зам дээр хийнэ. Гэхдээ замын эргэлт, огцом нугалаа, уулын хажуу налуу газарт отолт хийх байрыг сонгон авах нь ашигтай байсан. Афганистаны байлдааны үеийн нэг онцлог нь бие бүрэлдэхүүний үлэмж хэсэг нь байнгын байрлалаасаа тусдаа хамгаалалтын хаалт, цэгүүдэд байрлаж, чухал объект, зам харилцааны гол шугамыг хамгаалж байсан явдал юм. Ийм хаалт, цэг ойролцоогоор 400 орчим байлаа.

Тэдгээрийн заримтай нь зөвхөн нисдэг тэргээр харилцах боломжтой байсан нь тасралтгүй хангалтын асуудлыг хүндрүүлж байв. Байлдааны ажиллагааны туршлагаас үзэхэд мотобуудлагын тусгай батальоны отолтын амжилт нь түүнийг зохион байгуулах районд нууцаар гарч чадсан эсэхээс ихээхэн хамаарч байсан. Аливаа байлдааны ажиллагааг төлөвлөхдөө хамгийн нягт нямбай тооцон үзэж загварчлахаас бүрэн зайлсхийх хэрэгтэй.

Афганистаны нөхцөл дэх тусгай батальоны ажиллагааны тактик нь нэг маягийн, загварчилсан байж болохгүй гэдгийг харуулсан<sup>2</sup>. Иймд бүх шатны захирагч дарга нар тавигдсан байлдааны үүргийг хэрэгжүүлэх төлөвлөлтийг хийх тохиолдолд бүтээлчээр хандан байлдааны ажиллагаа явуулах шинэ арга хэлбэрийг эрэлхийлж, цэргийн ов мэхийг өргөнөөр ашиглах ёстой. Зөвхөн энэ тохиолдолд байлдааны ажиллагааны үр дүнг байнга дээшлүүлж, аль болох бага хохиролтойгоор амжилтанд хүрч чадна<sup>3</sup>.

## 1.2 АНУ-Иракийн дайн

Насарияг эзлэх ажиллагаа Америкийн Хуурай замын хүчний явган цэргийн 3 дугаар дивизийн тэргүүний үүрэг нь Талил хотыг эзлэхэд оршиж байсан ба энэ хотын ойролцоох нисэх онгоцны буудлыг эзэлж авснаар америкийн цэргийн байлдааны болон ар талын хангалтанд ашигтайгаас гадна америкийн цэргийн Нэгдсэн хүчний штабыг байлдааны ажиллагаанд ойртуулан байрлуулахад дөхөмтэй байсан юм. Талилын нисэх онгоцны буудлыг эзлэх зорилгоор нисдэг тэрэгний ангиудыг бэлтгэж байсан боловч америкуудын давшилтын үеэр шороон шуурга шуурч харагдах нөхцөл муу байсан тул давшилтаа явган цэргийн батальоноор шийдвэрлүүлэхээр болжээ. Артиллерийн галаар хэд хэдэн утаан хөшиг тавьж, түүний халхлалт дор ротуудыг давшуулсаар агаарын цэргийн баазыг хялбархан эзлэн авсан. Үүний дараагаар Насария хоттой хамгийн ойр байрлалтай Иракийн 11 дүгээр дивизийн байнгын байрлалыг эзлэхээр артиллерийн гал явуулж, дивизийн бүрэлдэхүүнд байсан танк, хуягт

<sup>3</sup> Шагдар, Б. (2002). Афганистанд байлдааны ажиллагаа зохион байгуулж явуулсан туршлага.

тэвэрлэгчдийг устгаад батальон хүртэл хүчээр дайрч дивизийн байрлалыг эзэлж авчээ. Багдадын төлөөх тулалдаан Генерал Д.Мкарнэн Багдадыг тойруулж цэргийн таван бааз байгуулж, чухал ач холбогдолтойг нь тооцон Багдадын олон улсын нисэх онгоцны буудлыг танкийн нэг бригадын хүчээр булаан авахаар төлөвлөж байсан.

Олон улсын нисэх буудлыг эзэлж авсанаар америкийн нэгдсэн хүчний командлал, явган цэргийн 3 дугаар дивизийн удирдлагын байр, ар талын хангалтыг байлдаж байгаа нэгтгэл, ангиудад хүргэх хамгийн ойрын баазтай болох онцгой ач холбогдолтой байжээ. Америкуудын Багдадыг эзлэх төлөвлөгөө нь дүр төрхийн хувьд Иракийг эзлэх байлдааны төлөвлөгөөний багасгасан хэлбэр байсан юм.

Америкийн тал

1-рт Багдадын төв дүүргийг буюу төв талбайг,

2-рт Баат намын төв хорооны байрлалыг эзлэх,

3-рт тэндээ бага хэмжээний баазтай болохоор төлөвлөжээ. Нисэх буудлыг эзлэх ажиллагаа дөнгөж эхэлмэгц иракуудын ширүүн эсэргүүцэлтэй тулгарч ихээхэн хүндрэл гарсан. Энэ байлдааны ажиллагааны үед явган цэргийн 3 дугаар дивизийн Бригадын байлдааны 2 дугаар бүлэг оролцсон бөгөөд тэдгээрийн дотроос Э.Шварцийн удирдсан батальон ихээхэн үүрэг гүйцэтгэж, тэдний батальоноос нэг цэрэг амь үрэгдэж, хоёр хүн шархдаж, нэг танкийн хохиролтой, харин иракийн талаас 2000 гаруй цэрэг алагдсан гэсэн тойм тооцоо гарчээ. Гуравдугаар дугаар дивизийн дараагийн үүрэг нь Багдад хотыг эзлэхэд оршиж байсан. Явган цэргийн 3 дугаар корпусын хурандаа Дэв Перкинс захирагчтай бригадын хоёрдугаар бүлэг ихээхэн үүрэг гүйцэтгэсэн.

Түүний командалсан бригадын байлдааны бүлэг Кувейтээс Багдад хүртэл байлдааны ихээхэн туршлага хуримтлуулж, Багдадын олон улсын нисэх буудлыг эзлэх ажиллагааг бие дааж гүйцэтгэсэн. Багдад хотыг эзлэх ажиллагаанд түүний батальонууд мөн томилогдож тэргүүн шугаманд байлдаж, нисэх онгоцны буудлаас дайсныг шууд зүсэж Багдадын төвд очиж байрлан тэндээ хориглолтод шилжин байлдсан. Бригадын байлдааны хоёрдугаар бүлгийн Багдадыг эзлэх ажиллагааг төлөвлөхдөө Э.Шварцийн батальоныг туршлагатайг нь бодолцож давшилтын үндсэн чиглэлд, Ф.Декампын хуягт-танкийн батальоныг Шварцын араас дагалдуулахаар,

Твитигийн явган батальоныг хангалтын замуудыг хамгаалуулахаар томилжээ. Давшилтын өмнө артиллерийн батареягаар ихэвчлэн задран дэлбэлэх сум ашиглаж явган цэргийн батальонуудын давшилтын чиглэлд хэсэг зуур галын бэлтгэл хийж Э.Шварц, Ф.Декампын батальонууд давшилтаа эхлүүлсэн. Артиллерчид замын уулзварын чиглэлд гал нээсэн нь дайсны амьд хүчийг аль болох олноор хөнөөж, батальонуудын явах замыг гэмтээхгүйг хичээж байжээ. Явган цэргийн батальонууд давшилтанд ормогц дайсны ширүүн эсэргүүцэлтэй тулгарч нэг танкныхаа шатахууны бак руу РПГ-7 танк эсэргүүцэгчээр буудуулан шатаалгажээ. Гэвч зогсолт хийвэл байлдааны ажиллагааны санаачлагыг дайсанд

алдах байсан тул шатаж байгаа танкийг орхиж хөдөлгөөнөө үргэлжлүүлсээр Багдад хотын төвд түвэггүй хүрчээ.

Явган цэргийн батальонууд буудлагын эсэргүүцлийг зүсэж, зогсолтгүй явсаар Багдадын төвд орсон. Д.Перкинсийн батальонууд Багдадын төвд орших цэргийн парадын талбайд хүрч тэндээ байлдаж, бааз байгуулан хориглолтонд шилжсэн. Иракууд, нэгэнт америкуудыг хотынхоо төв рүү алдсан тул түүнийг хангалтын замаас нь салгаж, бүсэлж авахаар шийдсэн. Хангалтын замыг Стеф Твиттигийн командалсан Бригадын байлдааны бүлэг хамгаалж ширүүн тулалдаж, иракийн бүх цэргүүд түүний батальон руу дайрч байсан.

Ингэх нь хүнд нөхцөлд байгаа Д.Перкинс руу хандсан галыг өөр дээрээ дуудаж байсан бас нэг онцлог байлаа. Бригадын хангалтын замыг хамгаалж байсан С.Твиттигийн батальон хүнд байдалд орж нэг хэсэгтээ Багдадын төвд орсон ангиудыг галт хэрэгслэл, шатахуунаар хангах боломжгүй болсон.

Багдадын төв дэх батальонууд галт хэрэгслэл, шатахууны нэг хоногийн нөөцтэйгээр байлдаж байгаа нь тэдэнд хангалт шаардлагатай байгаа нь тодорхой байсан тэр үед хангалтын байлдаантай замаар хангалт хийх эрсдэлтэй байсан ч америкууд оролдоод үзэхээр шийдсэн боловч иракуудын эсэргүүцэл тэднийг замд нь устгаж галт хэрэгслэл, шатахуун ачиж явсан таван машинаа шатаалгажээ. Ф.Декамын батальоныг хангалтын замын аюулгүй байдлыг хангахын төлөө тулалдаж байхад Д.Алиний бригадын Багдадыг баруун талаас нь хамгаалахаар томилогдсон Үндэсний гвардийн Хамурабигийн дивиз хориглолтонд орсон тул тэдний хуягт танкийн хэрэгслийг агаараас болон өөрийн орон тооны артиллерийн хэрэгслээр богинохон хугацаанд сөнөөж хөдөлгөөнөө цааш үргэлжлүүлсэн.

Хориглосон дайсны эсрэг тэмцэл явуулах нь сонгодог тактикийн хэлбэрээр явагдсан болохоор Д.Аллинд хүндрэлтэй нөхцөл байдал үүсээгүй. Д.Аллиний дараагийн үүрэг Багдадаас баруун тийш гарсан замын Тигрис мөрөн дээгүүр тавьсан гүүрүүдийг хяналтандаа авч, түүгээр хот руу орох гэсэн оролдлого байлаа. Энэ удаад иракууд гүүрийг хамгаалалтандаа авсан, түүгээр болж өгвөл сөрөх давшилтанд орохыг санаархаж байсан бололтой, голын цаад эрэг дээр нилээд хэмжээний хүч хуралдуулсан байв. Энэ үед агаарын цохилт дуудаж голын цаад эрэг дээр байгаа иракийн цэрэг, энгийн холилдсон бүрэлдэхүүнийг устгуулах арга хэмжээ авч, тэдэнд нэмэр болгож Аллин өөрийн орон тооны артиллерийн галыг дайсны байрлал руу шилжүүлжээ.

Гүүрний цаад талд байрлаж байсан иракуудыг агаараас бөмбөгдөж, Алиний артиллераар галалснаар Багдадын баруун хэсэг буюу Д. Алиний хариуцах хэсэг үндсэндээ аюулгүй болсноор Багдадыг эзлэх тулаан амжилттай хүрсэн. Дайны сургамж Байлдааны үндсэн ажиллагааны үед америкууд урьд өмнө яригдаж байгаагүй, дэлхийн цэргийн урлагт бичигдэж байгаагүй "сонирхолтой" гэмээр байлдааны ажиллагаа явуулжээ. Америкийн цэргийн үндсэн хүч Багдадын ойролцоо ирээд байхад тэдгээр анги нэгтгэлүүдийг хангах ар талын хангалтын зам нь 500 гаруй километр сунжирсан байлаа. Үүнийг зарим мэргэжилтнүүд "Rolling

Start" ("эхлэлийг үргэлжлүүлэх") болон "Bypass Criteria" (хажуугаар нь зөрж өнгөрөх) гэсэн онолоор тайлбарладаг.

Эхлэлийг үргэлжлүүлэх гэдэг нь давшилт эхэлж байхад нэмэгдэл хүч үргэлжлэн ирсээр байх гэсэн утгатай. Хажуугаар нь өнгөрөх гэдэг онолын хувьд, үндсэн гол зорилгоо биелүүлэхийн тулд туслах чанарын зорилгуудыг үлдээж хажуугаар нь өнгөрөнө гэсэн үг юм. Энд үндсэн зорилго нь Багдадыг эзлэх, харин туслах зорилгууд нь үндсэн зорилгыг биелүүлсний дараа "шийдвэрлэх" бусад хотууд байсан юм.

Дээрх хоёр онолоор явуулсан тактикийн ажиллагааны эцсийн үр дүнд америкийн цэргийн байлдааны үндсэн хүчний нэгтгэл, ангиуд Кувейтээс Багдад хүртэл үргэлжилсэн урт хангалтын замтайгаар Багдадын ойролцоо "түр зогсолт хийсэн байдаг. Гэхдээ ингэж хурдтай давших болсон шалтгааныг Саддамын ҮОХЗ-ээс урьдчилан сэргийлэх зорилготой байсан гэж судлаачид таамагладаг<sup>4</sup>. Хэрэв Иракийн нэгтгэл, ангиуд цагийн байдлыг зөв үнэлж, чадсан бол үндсэн хүчийг тасалж бүслэх боломжтой байсан ба америкуудыг бүр мөсөн устгахгүй юм гэхэд нилээд хэмжээний хохирол үзүүлж, америкуудыг цаашид байлдааны ажиллагаагаа үргэлжлүүлэх, эс үргэлжлүүлэх эсэхэд нөлөөлөх байсан.

### 1.3 ОХУ-Украины дайн

Украинд явагдаж буй цэргийн тусгай ажиллагааг "Дэвшилтэт технологийн зэвсгээр тоноглогдсон орчин үеийн Зэвсэгт хүчнүүдийн хооронд явагдан буй сүүлийн хэдэн арван жилд тохиолдоогүй хуурай замын анхны томоохон мөргөлдөөн" гэж олон улсын мэргэжилтнүүд онцолж байна.

ОХУ-ын явуулж буй цэргийн тусгай ажиллагаа нь алсын тусгалтай пуужингийн бөөгнөрүүлсэн цохилтуудыг Украины цэргийн онц чухал объектууд болон дэд бүтцүүдэд өгснөөр эхэлсэн байдаг. Ингэснээр ажиллагааны газар орон дээрх эсрэг талаас ирэх эсэргүүцлийг багасгаж чадна хэмээн тэд таамаглаж байв. Түүнчлэн ажиллагааны эхний үе шатанд ОХУ-ын Зэвсэгт хүчин Агаарын десант болон Тусгай хүчний анги нэгтгэлүүдийг өргөнөөр ашиглаж байсан. ОХУ-ын тактик нь галын хүчтэй цохилтоор эсрэг талыг туйлдуулснаар байлдааны хохирол багатайгаар Украиныг эзлэн авна гэсэн үзэл баримталж байсан.

Гэвч барууны дэмжлэгтэй Украины зэвсэгт хүчний хүчтэй эсэргүүцэлтэй тулгарсан явдал нь ОХУ цэргийн тусгай ажиллагаанд хэрэгжүүлж буй давшилтын арга барилаа өөрчлөх шаардлагад хүргэсэн. ОХУ-ын Зэвсэгт хүчний 5 Командлалуудад нийтдээ 170-175 орчим Батальоны тактикийн бүлэгтэй гэж үздэг. Үүнээс 90-100 орчим Батальоны тактикийн бүлгүүдийг Украин дахь хойд, урд, өмнөд фронтуудын чиглэлд хийх давшилтад хэрэглэсэн байдаг.

Харин 20-25 орчим Батальоны тактикийн бүлгийг нөөцөд буюу резервт үлдээсэн юм. Харин Украины Зэвсэгт хүчин хуурай замын цэрэг, десантын анги, салбарууд болон тусгай хүчний цэрэг ороод нийтдээ 90 орчим батальоны тактикийн бүлгийг байгуулж, хэрэглэх боломжтой байсан.

<sup>4</sup> Галбадрах, Т. (2022). ОХУ болон Украин улсын хоорондын зэвсэгт мөргөлдөөний явц, сургамж

ОХУ-ын Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн ажиллагаа ОХУ цэргийн тусгай ажиллагааг эхлүүлэхдээ стратегийн тагнуулын мэдээ, түүнээс гаргасан дүгнэлтийг эш үндэс болгон уламжлалт тактикийн аргад суурилан, томоохон хүчээр үндсэн болон туслах чиглэлүүдээр давшилтыг эхлүүлжээ. ОХУ Крым болон Беларусийн нутгаас Украинд халдан довтолсон бөгөөд уг цэргийн тусгай ажиллагаанд Донецкийн Бүгд Найрамдах Улс (ДБНУ) болон Луганскийн Бүгд Найрамдах Улсын (ЛБНУ) цэргүүд мөн оролцсон юм. ОХУ-ын хуурай замын цэргийн ажиллагаа нь Киевийн хойд талаас, Харьковын зүүн хойноос, Донбассын зүүн урдаас болон Крым талаас гэсэн 4 чиглэлд төвлөрсөн ба артиллер, пуужингийн цохилтоор Украины агаарын довтолгооноос хамгаалах систем, аэродромуудыг жагсаалаас гарган цаашлаад зарим орон нутгийн болон цэргийн чухал объектуудыг тэнгисийн цэргийн болон агаарын десантын тусгай анги салбаруудаар хяналтандаа авсан.

ОХУ-ын зэвсэгт хүчний хуурай замын цэргийн дийлэнх хэсгийг холимог зэвсэглэлтэй рот, батальонуудаас бүрдсэн Бригадад харьяалагдах Батальоны тактикийн бүлгүүд бүрдүүлж байна. Оросын Армийн Батальоны тактикийн бүлгүүд нь тэдгээрийн хүн хүч болон гүйцэтгэх үүрэгт суурилж зохион байгуулагдах ба ойролцоогоор 600-800 орчим цэрэгтэй байдаг. Эдгээр тактикийн бүлгүүд нь ерөнхийдөө механикжсан батальонууд бөгөөд, хоёроос дөрөв хүртэлх танктай, мотобуудлагын рот байх ба артиллери, тагнуул, инженер, электрон тэмцэл болон ар тал хангалтын салаадаар (тээврийн, хүнс хангалтын, засварын, эрүүл ахуйн) хүч нэмэгдүүлсэн байдаг. Онолын хувьд энэ нь галын болон ар талын дэмжлэг бүхий харьцангуй бие даасан хуурай замын байлдааны нэгж юм. Гэвч практик дээр батальоны тактикийн бүлэг нь хүч сул бөгөөд явган цэргүүдээр дутмаг байгаа нь харагдаж байна.

Үүнээс үүдэн ОХУ-ын хуурай замын хүчин Украин дахь тусгай ажиллагааны явцад дараах бэрхшээлтэй тулгарч эхэлсэн.

Нэгдүгээрт, ОХУ-ын Зэвсэгт хүчин Украины бүс нутагт тусгай ажиллагаа явуулах явцад ар талын болон засвар хангалтын ноцтой асуудлууд үүссэн. Тэдний ашиглаж буй тактик нь сонгомол хэлбэрээр буюу ерөнхийдөө Украины цэргийн байрлалуудад хуралдуулсан галыг артиллер болон пуужингийн цохилтоор өгч улмаар хуягласан техникээр давшилтыг зохион байгуулж хориглолтын шугамд амьд үлдсэн хүчийг дарах арга ажиллагаа байв. Гэвч Украины зэвсэгт хүчин Оросын цэргийн хүчний эсрэг танк болон агаарын довтолгооноос эсэргүүцэн хамгаалах залуурт пуужин болон цэнэгт хошуу бүхий дронуудыг амжилттай ашиглан маневрын хориглолтыг хийж байсан нь Оросын хуурай замын хүчний давшилтад ихээхэн хүндрэл учруулж байжээ. Гэхдээ цэргийн ажиллагаа эхэлснээс 48 цагийн дотор Оросын хуурай замын зарим хуягт ангиуд нь Киевийн захын дүүргүүдэд хүрч байснаас маш хурдтай давшиж байсан нь харагдаж байсан. Үүнээс үүдэн Оросын хэд хэдэн анги салбарууд нь гол хүчнээсээ олон арван километрийн урд тасран үлдсэнээр, тэдний үндсэн хангалтууд хязгаарлагдаж хүнд нөхцөлд орж байсан. Украины нутаг дэвсгэрт нэвтэрсний дараа Оросын армийн

хүнд техникүүдийг зөөвөрлөх төмөр зам байхгүй, цаашлаад тээвэрлэлт зохион байгуулах боломжтой авто замууд нь ачааллаа дийлэхгүй түгжрэлд орж байсан зэрэг шалтгаануудаас болж цэргүүддээ хүнс, шатахуун, зэвсэг, сэлбэг хэрэгсэл гэх мэт чухал хангалтуудыг хийхэд ихээхэн хүндрэл бэрхшээлтэй тулгарч байв. Мөн ар талын хангалтуудыг тээвэрлэж буй цувааны аюулгүй байдлыг хангаж чадаагүйгээс болж эдгээр асуудал улам бүр нэмэгджээ. Товчхондоо бол ОХУ-ын Зэвсэгт хүчин харилцан ажиллагааны чухал хэсэг болох аюулгүй байдлыг хангах тал дээр алджээ (Vershinin, 2022). Үүнээс үүдэн Киевийн чиглэлд хийгдэх давшилт асар өндөр үнээр урагшилж байсан. 2022 оны 2 дугаар сарын сүүлээр Оросын цэргүүд давшилтад бэлтгэн Хостомелийн нисэх буудлыг хамгаалан байрлаж байх үед Киев хотыг эзлэн авах байлдааны хүч дутаж байв. Давшилтын үед Оросын ангиуд Украины артиллерийн зэвсгийн хөнөөлийн бүсэд орж ирсэн ба нутгийн гүн тийш давших тусам галын хөнөөл илүү өндөр болж байсан. Мөн Оросын анги, нэгтгэлүүдийн Харьков хотыг эзлэх оролдлого бүтэлгүйтсэнээр ар тал хангалтын асуудалтай дахин тулгарав. Өрнөдийн зүгээс тавьж буй хориг арга хэмжээнээс улбаалан өндөр түвшний шинэ технологийн бүтээгдэхүүнүүд ОХУ-д нийлүүлэгдэхээ больсон явдал нь Москва сунжирч буй хуурай замын байлдааны ажиллагааг зохион байгуулж явуулах чадвараа алдахад хүргэж болзошгүй байна. Жишээ нь, шаардлагатай эд ангийн (ялангуяа нарийн электроникийн материалын) хомсдлоос үүдэн Оросын хоёр ч томоохон танк үйлдвэрлэгчид үйлдвэрлэлээ зогсооход хүрээд байна. Оросын Арми Украины зэвсэгт хүчний эсрэг маневрын байлдаан хийхийн оронд хот, тосгодыг агаараас бөмбөгдөх болон пуужингийн цохилт өгөхийг илүүд үзжээ. ОХУ-ын Зэвсэгт хүчин холимог зэвсэгт анги нэгтгэлийнхээ харилцан ажиллагаа, уялдаа холбоог хангах замаар байлдааны ажиллагааг үр дүнтэй явуулж чадаагүйгээс тэдэнд тулгарах бэрхшээлүүд улам хүндрэлтэй болж ирсэн. Украины хойд хэсэгт байрлаж байсан Оросын механикжсан ангиуд нь орчин үеийн танк эсэргүүцэх залуурт пуужингаар зэвсэглэсэн Украины явган цэргүүдэд хялбар бай болж байв. Үүнээс үүдэн Оросын армийн галын болон маневрлах чадварын талаарх эргэлзээтэй асуудлууд бий болов. Украины Зэвсэгт хүчний хуурай замын цэргийн ажиллагаа ОХУ-ын явуулж буй цэргийн тусгай ажиллагаанд Украины Зэвсэгт хүчин нь давуу хүчний түрэмгийллийн эсрэг жижиг хөдөлгөөнт бүлгүүдээр байлдаж байгаа бөгөөд тактикийн шинэ аргуудыг хэрэглэж байна. Жишээлбэл: Украины Зэвсэгт хүчин томоохон цэргийн бүлэглэлийг ашиглахаас татгалзаж, батальон, ротын тактикийн бүлгүүдийг байгуулан түүний хэрэглэх аргад шилжсэнээр цөөн тооны хүч, бүрэлдэхүүнтэй хөдөлгөөнт бүлгүүдийг үр дүнтэй ашиглаж байна. Зэвсэг техникийн хохирол, шатах тослох материалын хомсдол, дэд бүтцийн сүйрэл, цаашлаад ОХУ-ын Зэвсэгт хүчний агаарт давамгайлах боломж зэрэг нь Украины Зэвсэгт хүчнийг цэргийн томоохон бүлэглэлийг нэгдмэл байдлаар хэрэглэхээс татгалзахад хүргэж, рот, салбаруудын тактикийн бүлгүүдийг эмхлэн байгуулах шалтгаан болж байна. Ийм тактикийн бүлгүүд нь 20-25 хүртэлх явган цэргийн байлдааны машин болон хуягт тээвэрлэгч бүхий 250-450 цэргийн алба хаагч,

эсвэл 10-12 нэгж байлдааны танк байх бөгөөд 6-12 өөрөө явагч артиллери чиргүүлийн гаубиц, болон 6 хүртэлх тийрэлтэт артиллерийн хэрэгслээр хүчжүүлсэн байдаг. Мөн дээрхээс гадна Украйны Зэвсэгт хүчин хөдөлгөөнт жижиг бүлгүүдийг Оросын армийн анги нэгтгэлийн эсрэг идэвхтэй хэрэглэж байна. Тэдгээр жижиг бүлгүүд нь хоёр төрөлд хуваагддаг ба эхнийх нь голдуу 4 нэгж байлдааны танк, 3 нэгж явган цэргийн байлдааны машинтай байх бөгөөд түүнчлэн "бандермобил" гэж нэрлэгддэг хөдөлгөөнт хэрэгслүүд бүхий зэвсэглэлээр хангагдаж байна. Ийм бүлгийн галын хүч нь хотын тактикийн бүлэгтэй харьцуулахад тийм ч их биш боловч өндөр хөдөлгөөнтэй чанараараа тэднийг давж гарч байгаа юм. Эсэргүүцэлтэй тулгарсан нөхцөлд иймэрхүү хөдөлгөөнт бүлгүүд шууд байлдаанаас аль болох зайлсхийж, тэр даруйдаа ухардаг байна.

Хоёрдахь төрлийн хөдөлгөөнт бүлэг нь танк эсэргүүцэх зөөврийн хэрэгсэл, миномёт, автомат гранатомёт, пулемётоор зэвсэглэсэн, туулц сайтай тээврийн хэрэгсэл бүхий 3-6 цэргийн алба хаагчаас бүрдсэн бүлгүүд байна. Ихэнхдээ "бандермобил" дээрх ийм жижиг хөдөлгөөнт бүлгүүд нь ОХУ-ын Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын завсар хооронд нэвтрэх, цэргийн цуваа ба ар тал, холбооны эмзэг зангилаанууд руу дайрах, удирдлагын байрууд руу довтлох зэрэг ажиллагааг амжилттай зохион байгуулсан байдаг.

Мэргэн буудагчид нь ихэвчлэн 12.7 калибрын "Barrett M82" загварын мэргэн буудагчийн буугаар зэвсэглэсэн байдаг бөгөөд энэ нь алсын зайнаас танк, явган цэргийн байлдааны машин, тээврийн хэрэгслийн жолооч нарт хөнөөл үзүүлэх боломжийг олгодог. Ингэснээр танк эсвэл явган цэргийн байлдааны машины хөдөлгөөнийг саатуулдаг байна. Украйны Зэвсэгт хүчин нисгэгчгүй нисэх хэрэгслүүдийг ОХУ-ын зэвсэгт хүчний хориглолтын зурвас дахь цэргийн хүчийг тогтооход хэрэглэсээр байна. Украйны Зэвсэгт хүчин АНУ-аас нийлүүлэгдэж байгаа камикадзе дрон (Switchblade) болон Туркээс нийлүүлэгдэж буй "TB-2" Байрактар дроныг түлхүү ашиглаж байгаа бөгөөд эдгээр нь агаарт удаан хугацаагаар нисэх боломжтой ба үндсэндээ тактикийн далавчит пуужингийн адилаар хэрэглэгдэж байна.

Мөн Украйны талаас дайсны хүчийг устгах зориулалт бүхий дээрх дронуудаас гадна цель заах, артиллерийн гал чиглүүлэх болон тагнуул хийх зорилгоор иргэний, жижиг хэмжээний нисэгчгүй нисэх төхөөрөмжүүдийг үр дүнтэйгээр ашиглаж байна. Эдгээр нисэгчгүй нисэх төхөөрөмжүүдийг хөөргөхөд том хэмжээний талбай шаардагдахгүй бөгөөд зарим төхөөрөмжийг гараас хөөргөдөг нь байлдааны ажиллагааны үед ач тустай байна.

Талуудын хуурай замын цэргийн ажиллагааны явц, өрнөлийг дүгнэн үзвэл

ОХУ уламжлалт давших байлдааны онолоор дашилт эхлүүлсэн боловч бүх төрлийн цэргийн харилцан ажиллагааг зохион байгуулахад ноцтой алдаа гаргасан. Дашилтын чиглэлүүдээр гол хүчний бүрэлдэхүүний хөдөлгөөнийг хангаагүйн улмаас тактикийн агаарын десант бүтэлгүйтсэн. Түүнчлэн энэ хөдөлгөөнийг хангаагүй дутагдал нь материал техникийн хангалт цаг хугацаандаа цэрэгт

хүрээгүйгээс давшилтын хурдыг бууруулж (зогсоосон) байлдах чадваргүй болгосноор эсрэг талд маневр үйлдэх, нөхөн сэргээх боломж олгоод зогсохгүй зарим хэсэгт сөрөг давшилтад шилжих нөхцөл бий болгосон.

Механикжсан бригад, батальоны тактикийн бүлгүүдийн бүтэц, зохион байгуулалтаар хуурай замын цэргийг хэрэглэсэн боловч хуягт хэрэгслийг хамгаалах явган цэргийн ажиллагаа дутагдаж эсрэг талын хөнгөн жижиг буюу рот хүртэл хүчтэй тактикийн бүлгүүдийн отолтод асар их хохирол амссан. Украйны талын туршлагаас харахад рот хүртэл бүрэлдэхүүнтэй жижиг тактикийн бүлгүүдийг хэрэглэх давуутайг харж болохоор байна. Харин тактикийн бүлгүүдийн бүтэц зохион байгуулалт, зэвсэглэлийг гүйцэтгэх үүрэг, эсрэг талын хүч хэрэгсэл, хөдөлгөөн үйлдэх чадвар, галын боломжоос харгалзан бүрдүүлдэхийг анхаарах нь зүйн хэрэг. Хэдийгээр жижиг бүлгүүдээр эсэргүүцэл үзүүлж байгаа боловч түүнийг дэмжих цохилтын болон галын хэрэгслийн харилцан ажиллагааг маш чадварлаг зохицуулж байгаа нь туршлага болж байна.

#### Хоёр. МББ-ы давших байлдааны цаашдын хөгжлийн чиг хандлага

Хэдийгээр шинжлэх ухаан, техник технологийн өндөр хурдацтай хөгжил, дэвшил, шинэ зэвсэглэл, байлдааны техникийн нөлөөгөөр байлдааны ажиллагаанд ихээхэн өөрчлөлт орж байгаа боловч үндсэн төрлийн байлдааны ажиллагаа уламжлагдан хадгалагдсаар байна. Артиллерийн галын дэмжлэг Мотобуудлагын батальон нь дашилт эхлэхийн өмнө артиллер, авиацийн хүчтэй галаар дайсанд хөнөөл үзүүлж, байлдааны журам, удирдлага зохион байгуулалтыг алдагдуулан, дайсны амьд хүч, галын хэрэгслүүдийг устгаж хөнөөл үзүүлэн дашилт эсэргүүцэх ажиллагааг нь саатуулан дашилтыг эрчимтэй хийснээр амжилтад хүрсэн тохиолдлууд одоог хүртэл амжилттай хэрэгжсээр байна. АНУ-Иракийн дайны үед Иракийн Талил хотын нисэх онгоцны буудал, Иракийн 11 дүгээр дивизийн байнгын байрлалыг эзлэх үед артиллерийн гал явуулж, дивизийн бүрэлдэхүүнд байсан танк, хуягт тээвэрлэгчдийг устгаад мотобуудлагын батальон хүртэл хүчээр дайрч эзэлж авчээ. Мөн Багдад хотыг эзлэн авах байлдааны үед давшилтын өмнө артиллерийн батареягаар ихэвчлэн задран дэлбэлэх сум ашиглаж мотобуудлагын батальонуудын давшилтын чиглэлд галын бэлтгэл хийснээр Э.Шварц, Ф.Декамын мотобуудлагын батальонуудын давшилтаар Багдад хотын төвд хүрэхэд ихээхэн чухал нөлөө үзүүлсэн.

Мөн ОХУ-Украйны дайнд мотобуудлагын батальонууд ашиглаж буй тактик нь сонгомол хэлбэрээр буюу хуралдуулсан галыг артиллер болон пуужингийн цохилтоор өгч улмаар хуягласан техникээр дашилтыг зохион байгуулж хориглолтын шугамд амьд үлдсэн хүчийг дарах арга ажиллагаа байсан. Тагнуул, отолт Афганистаны нутаг дэвсгэрт мотобуудлагын тусгай батальон нь тагнуулын ба тусгай олон төрлийн үүрэг гүйцэтгэж байсан. Тусгай томилолтын тагнуулын бусад төрлийн тагнуултай нягт харилцан ажиллагаатайгаар тагнуулын бүлэг, отрядын идэвхтэй ажиллагаатай хослуулсан аргаар зохион байгуулан явуулж байсан. Тусгай томилолтын тагнуул нь самуун дэгдээгчдийн цувааг илрүүлж устгах, Исламын хороод, дээрэмчдийн бүлгүүд, зэвсэг галт хэрэгслийн агуулах,

баазуудыг устгах (бут цохих) тусгай арга хэмжээ явуулах үндсэн зорилготой байсан. Эдгээр үүргүүдийн багтаамж, агуулга нь цагийн байдлын нөхцөл, юуны урьд бүлэг, отрядын ажиллагаа явуулах арга (дайралт ба отолт), тагнан эрж илрүүлэх районоос хамаарч байсан. Мотобуудлагын тусгай батальоны байлдааны ажиллагааны туршлагаас үзэхэд батальоны байлдааны ажиллагааны үндсэн арга нь отолт байсан. Отолт нь ажиллагааны бусад аргуудаас нэлээд давуу талтай байсан. Тухайлбал дайсныг тэдний хувьд санаанд ороогүй, эвтэйхэн газарт нуугдан хүлээж, ойрын зайнаас гэнэтийн хүчтэй галаар сандралд оруулан, зохион байгуулалттай эсэргүүцэл үзүүлэх боломж олголгүйгээр устгах боломжийг олгож байсан. Туршлагаас үзэхэд тагнан илрүүлэх районд бүлгийг 2-3 хоногийн хугацаагаар гаргаж, отолт зохион байгуулах нь үр дүнтэй байсан. Тэр тусмаа шөнийн цагт дайсныг отолтонд оруулж байлдах нь хамгийн үр дүнтэй байсан.

Цаашид ч мотобуудлагын батальоны давших байлдаанд артиллерийн галын дэмжлэг, тагнуул үнэн бодит мэдээ дайсны жижиг бүлгүүдийг тохирсон хүч хэрэгсэлтэй тактикийн жижиг бүлгүүдээр отолтоор устгаж гол хүчний давшилтыг амжилттай үргэлжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэх хандлагатай байна. Дэлхийн цэргийн хүчирхэг гүрнүүд дайн, байлдааныг өөрсдийн хүчтэй зэвсэгт хүчиндээ тохирсон, орчин үеийн зэвсэг, техникийн давуу чанарыг ашиглан явуулахыг зорьсоор байна.

Гэтэл хүчээр сул талд давуу хүчтэй дайсны эсрэг уламжлалт онолын дагуу хориглолтын шугамуудыг барьж, эсэргүүцлийн зангилаануудыг байгуулан идэвхтэй хориглон хамгаалах байлдааныг явуулах бололцоо гардаггүй учраас өөрсдийн хүчинд тохирсон дайтах аргыг сонгож байна. Мэдээж хүч сул тал нь эсрэг талынхаа дайралтыг тогтоон барьсан хориглох, саатуулах байлдааныг явуулж чадахгүй учир ийм цагийн байдалд хүч сул тал нь нууц далд байдлаар явуулах жижиг бүлгийн дайнд шилжих (ЗХУ-Афганистан, ОХУ-Украйн) хандлагатай байна. ОХУ-ын явуулж буй цэргийн тусгай ажиллагаанд Украины Зэвсэгт хүчин нь давуу хүчний түрэмгийллийн эсрэг жижиг хөдөлгөөнт бүлгүүдээр байлдаж байгаа бөгөөд тактикийн шинэ аргуудыг хэрэглэж байна. Жишээлбэл, Украины Зэвсэгт хүчин томоохон цэргийн бүлэглэлийг ашиглахаас татгалзаж, батальон, ротын тактикийн бүлгүүдийг байгуулан түүний хэрэглэх аргад шилжсэнээр цөөн тооны хүч, бүрэлдэхүүнтэй хөдөлгөөнт бүлгүүдийг үр дүнтэй ашиглаж байна.

Том армийн орчин үеийн зэвсгийн цохилтонд өртөхгүйн тулд хүчээр сул талын зэвсэгт хүчин байлдааны жижиг бүлгүүдэд хуваагдан тарж, нууц далд байдалд шилжиж байна. Нэгэнт нууц далд байдалд шилжсэн тэмцлийн хүч байнгын үргэлжилсэн байлдааныг явуулдаггүй, зөвхөн тохиромжтой цаг хугацаанд, байлдахад өөрт ашигтай газар орныг сонгон авч түр зуурын жижиг байлдаануудыг явуулахад хүрдэг. Энэ нөхцөлд зэвсэгт тэмцлийн ажиллагаа хүчээр сул талын сонгосон тэмцлийн хэлбэрт хөтлөгдөн зөвхөн жижиг бүлгүүдийн байлдаанаар явагддаг. Ийм байлдаан нь зөвхөн хоёр талаас

байлдааны жижиг бүлгүүдийн хүчээр явагддаг учраас үүнийг олон улсын цэргийн нэр томъёонд “Жижиг бүлгийн байлдаан” хэмээн нэрлэж байна.

Батальон нь тактикийн жижиг бүлгүүдээр олон хэлбэрийн байлдааны ажиллагааг явуулах боломжтойгоос гадна үндсэн төрлийн байлдаанд бие дааж үүрэг гүйцэтгэх чадвартай тактикийн үндсэн нэгж юм. Орчин үеийн байлдааны үндсэн үүргийг биелүүлэхэд ерөнхий цэргийн анги, салбарууд дотороос хамгийн тохиромжтой нэгж нь олон талын үүрэг гүйцэтгэх чадвартай, тактикийн жижиг бүлгүүдээр байлдахад зохицсон, маневрын өндөр чадвартай мотобуудлагын батальон байхаар байна<sup>5</sup>. Мотобуудлагын батальон нь жижиг бүлгийн байлдааны үндэс байна гэдэг нь батальон бүрэн бүрэлдэхүүнээр жижиг бүлгийн байлдаан явуулна гэсэн ойлголт биш юм. Харин батальоноос гарах олон хэлбэрийн жижиг бүлгүүд нь төрөл бүрийн байлдааны үүргийг тэр үүрэгт тохирсон жижиг бүлгийн хүчээр гүйцэтгэж үүнийг батальоны штаб удирдаж явууласнаар бага хүчээр их хүчийг тогтоон барих, бага хүчээр хүчтэй цохилт үзүүлж үлэмж хохирол учруулах хандлагатай байна.

### Дүгнэлт

Хөгжингүй орнуудын зэвсэгт хүчин улам бүр хүчирхэгжиж цаашид явагдах дайн байлдааны ажиллагаа хүч тэнцвэргүй дайны шинжтэй явагдах хандлагатай байна. Иймд хүч тэнцвэргүй дайнд жижиг улс орнууд хөгжингүй орнуудын хүчирхэг зэвсгийн цохилтоос зайлсхийх, хүч хэрэгслийг гамнахын тулд жижиг бүлгүүдийн байлдааны ажиллагааг явуулж, бага хүчээр их хохирол үзүүлэх ажиллагааг бэлтгэн явуулж байна. МББ-ы давших байлдааныг тактикийн жижиг бүлгүүдээр явуулах шаардлага тулгарч байна.

Тактикийн жижиг бүлгүүдээр байлдааны ажиллагааг явуулахад:

- МББ-ы тактикийн бүлгийн хуягт тээвэрлэгчдийг хамгаалах, хөнгөн жижиг тэрэгтэй явган цэргээр хүч нэмэгдүүлэх;
- Отолтыг өргөнөөр ашиглах;
- Ар талын хангалтыг тасралтгүй зохион байгуулах шинэлэг арга хэлбэрүүдийг ашигласнаар хангагдана.

### Эш татсан сурвалж, судалгааны бүтээлийн жагсаалт

- [1] Паламдорж, Ш., & Дашзэвэг, Ц. (2020). Цэргийн ерөнхий тактик.
- [2] Шагдар, Б. (2002). Афганистанд байлдааны ажиллагаа зохион байгуулж явуулсан туршлага.
- [3] Баярсайхан, Д. (2007). Иракийн дайн.
- [4] Галбадрах, Т. (2022). ОХУ болон Украин улсын хоорондын зэвсэгт мөргөлдөөний явц, сургамж.
- [5] Цогтжаргал, Ч. (2010). Жижиг бүлгийн байлдааны үндэс.
- [6] Түмэн, Б., Ганзориг, Г., & Баярбат, Г. (2021). Цэргийн урлагийн түүх.
- [7] Аюулгүй байдал стратегийн тойм (2023). Стратеги судлалын хүрээлэн, дугаар №16

<sup>5</sup> Цогтжаргал, Ч. (2010). Жижиг бүлгийн байлдааны үндэс.